

ХОВД АЙМАГ ДӨРГӨН СУМ

ТЭМЭЭ ӨСГӨХ ДЭД ХӨТӨЛБӨР

2014 ОН

ДӨРГӨН СУМЫН ТЭМЭЭ ӨСГӨХ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

1. Сумын үндсэн салбар нь мал аж ахуй бөгөөд орон нутгийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтэнд онцгой байр суурь эзэлдэг уламжлалт салбар мөн. Тус сум нь тэмээний тоогоор сүүлийн жилүүдэд аймагтай тэргүүлж байна. Жил бүр 300-450 ботго хүлээн авдаг ба 18-20 тн ноос бэлтгэдэг. Мөн 15-18 тн ингэний айраг бэлтгэн нийлүүлэх нөөц боломжтой.

Малчид эрт дээр үеэс тэмээ маллаж ирсэн арвин туршлагатай, өрх бүхэн саалийн ингэтэй болох боломжтой, ингэний айраг, үржлийн буур, ингэ бойжуулан орон нутаг болон аймгийн төв, зэргэлдээх аймаг суманд борлуулах зах зээлтэй, тэмээний нутаг бэлчээр арвинтай. Энэ нөөц бололцоонд тулгуурлан тэмээ өсгөн үржүүлж цаашид тэмээний ноос боловсруулах, ингэний айраг савлах жижиг үйлдвэр байгуулж нутгийн брэнд бүтээгдэхүүн гаргах, тэмээний үүлдэр угсааг сайжруулж чанаржуулах шаардлагатай байна.

2. Өнөөгийн байдал.

Манай сум нь 1996-оны жилийн эцэст 2780 тэмээ тоолуулж энэ нь 1999 оны жилийн эцэс гэхэд хүртэл 3031 болтлоо өссөн байна. Харин 2000 оноос энэ тоо толгой буурч 2002 оны жилийн эцэст 1807 болтлоо буурсан байна. 2003 оноос эхлэн 2013 оны жилийн эцэс хүртэл 3272 хүртлээ өссөн дүн мэдээтэй байна. Энэ нь 2004 онд тэмээ өсгөх журам боловсруулан ажилласантай холбоотой гэж үзэж байна.

2013 оны жилийн эцсээр манай сум 607 ботго бойжуулж, 1074 ингэ тоолуулсан байна. Энэ нь нэг талаас тэмээчдийн хөдөлмөрийн үр дүн нөгөө талаас орон нутгийн бодлогын нэгдсэн ойлголтонд хүрсэн явдал юм.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго

Тэмээн сүргийн тоо толгойг өсгөж нэмэгдүүлэх, үүлдэрлэг байдал, чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болж, аялал жуулчлал хөгжүүлж эдийн засгийн чадавхиа дээшлүүлэх малчин бүрийг тэмээтэй болгоход энэхүү хөтөлбөрийн гол зорилго оршино.

Гурав: Хөтөлбөрийн зорилт

3. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна.

3.1. Хөтөлбөрийн зорилго ач холбогдлыг олон нийтэд сурталчлан ойлгуулах,

3.2. Хөтөлбөрт бүх малчин өрхийг хамруулах

3.3. Тэмээн сүргийн тоо толгойг өсгөхийн зэрэгцээ ноос, сүүн ашиг шим болон уналга эдэлгээнд сургах.

Дөрөв: Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа

Тэмээн сүргийн дотор шилэн сонголт явуулж нутгийн шилмэл сүрэг бий болгож хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж үржилд ашиглах.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

а/ Үржлийн буур ингэ худалдан авах

б/ Тэмээний ноос угаах ,эцсийн бүтээгдэхүүн гаргах

в/ Ингэний айраг савлах үйлдвэр байгуулах.

г/ бойжуулсан ботго тутамд мөнгөн урамшуулал олгох.

д/ Тэмээчдийн чуулга уулгалт зохион байгуулах

е/ Аялал жуулчлал хөгжүүлэх

Тав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

5.1. 2015-2019, 2019-2025 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Зургаа. Хүрэх үр дүн

1. Тэмээн сүргийн тоо толгойг өсгөх таатай нөхцөл бүрдүүлж идэвхи сонирхолыг дээшлүүлэх замаар нийт тэмээн сүргийн тоо толгойг өсгөж. 2025 онд 10000 мянга буюу 1 түмд хүргэнэ.

2. Нутгийн шилмэл тэмээний тоог 2000 мянгад хүргэх

3. Нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болох.

4. Тэмээний түүхий эд ашиг шимд суурилсан жижиг дунд үйлдвэрлэл байгуулах.

**Тэмээний тоо толгойн өсөлт бууралтын судалгаа, өсөх
түвшингийн тооцоолол**

№	Он	Тоо	Өсөлт бууралт	№	Он	Тоо	Өсөлт
1	1996	2780		16	2011	2734	+271
2	1997	2895	+115	17	2012	3107	+373
3	1998	2928	+33	18	2013	3272	+165
4	1999	3031	+103	19	2014	3672	+400
5	2000	2583	-448	20	2015	4272	+600
6	2001	2265	-318	21	2016	4722	+450
7	2002	1807	-458	23	2017	5372	+650
8	2003	1935	+128	24	2018	5872	+500
9	2004	2129	+194	25	2019	6572	+700
10	2005	2257	+128	26	2020	7122	+550
11	2006	2501	+244	27	2021	7872	+750
12	2007	2689	+188	28	2022	8472	+600
13	2008	2764	+75	29	2023	9272	+800
14	2009	2599	-165	30	2024	9882	+610
15	2010	2463	-136	31	2025	10632	+750

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

/мян.төг/

№	Хэрэгжүүлэх ажил	Тоо	Зарцуулагдах Хөрөнгө мян ₮	Хугацаа	Хариуцах эзэн	Хөрөнгийн эх үүсвэр
1	Үржлийн буур худалдан авах Говь алтай Төгрөг сум	10	20,000,0 /хорин сая/	2015	МЭҮТ Малчин	ОНХС
2	Үржлийн ингэ худалдан авах Говь алтай Төгрөг сум	20	30,000.0 /Гучин сая/	2015-2019	МЭҮТ Малчин	Малчдын хандив
3	Тэмээний ноос боловсруулах ЖДҮ байгуулах	1	100,000,0 сая /Нэг зуун сая/	2016	ИТХ,СЗД, бизнес эрхлэгчид	Хувийн хөрөнгө оруулалтаар
4	Ингэний айраг савлах үйлдвэр	1	20,000,0 /Хорин сая/	2015	СЗД,	Сум хөгжүүлэх сангаас
5	Бойжуулсан ботго тутамд өгөх мөнгөн урамшуулал	550	5500.0 сая /Таван сая таван зуун мянга/	Жил бүр 2015 оноос эхэлнэ	ИТХ,Сум багийн ЗД	ОНХС
6	Тэмээчдийн чуулга уулзалт зохион байгуулахад	5	3000,0 /гурван сая/	2015-2025 2 жилд 1 удаа	ИТХ,Сум багийн ЗД МЭҮТ	Улсын төсөв